ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 2
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл 2
1.2 2026 оны жилийн хүчин чадал, ашиглах хугацаа 3
1.3 Уурхайн дэд бүтэц 5
ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 8
2.1 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим 10
2.2 Төслийн гол сөрөг нөлөөллийг үнэлэх 13
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 16
3.1Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 17
3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 18
3.3Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 19
3.4Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 19
3.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 19
3.6Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 20
3.7Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 21
3.8Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр 22
3.9Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 23
3.10. Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө. 24
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ 25

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл


ТӨСЛИЙН НЭР:	**“Зүүн түрүүн”** нэртэй элсэн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ: РЕГИСТРИЙН ДУГААР:	“Сүр сүлд” ХХКомпани- 9011818030 6570313
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 20-р хороо, Бэлх Цуурайт 1, 184 тоот. Утас: 86612288
АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:	Дугаар: 21/М037/87.35 га/
ТӨСЛИЙН БАЙРШИЛ:	Тус орд нь Улаанбаатар хотын төвөөс баруун хойд зүгт 21 км-т, УБ-Дархан чиглэлийн автозамын шалган бүртгэх 22-ын (шинэ) товчооноос чанх зүүн зүгт 3км-т Сонгинохайрхан дүүргийн 33-р хорооны нутагт оршино.

Тус орд нь Улаанбаатар хотын төвөөс баруун хойд зүгт 21 км-т, УБ-Дархан чиглэлийн автозамын шалган бүртгэх 22-ын (шинэ) товчооноос чанх зүүн зүгт 3км-т Сонгино хайрхан дүүргийн 33-р хорооны нутагт оршино.

Хүснэгт 1. Талбайн солбицлын цэгүүд:

Булангийн цэг	WGS-84						UTM	
	Уртраг			Өргөрөг			Уртраг	Өргөрөг
	градус	минут	секунд	градус	минут	секунд	м	м
1	106	38	12.99	47	55	46.01	622273.21	5309755.38
2	106	39	24.99	47	55	46.01	623767.09	5309787.27
3	106	39	24.99	47	55	25.01	623781.01	5309138.95
4	106	39	1.05	47	55	25.01	623284.24	5309128.31
5	106	39	1.05	47	55	32.00	623279.62	5309344.11
6	106	38	39.74	47	55	32.00	622837.44	5309334.67
7	106	38	39.74	47	55	25.01	622842.04	5309118.87
8	106	38	12.99	47	55	25.01	622286.96	5309107.07
9	106	38	12.99	47	55	46.01	622273.21	5309755.38

Зураг 1. Төслийн байршил



1.2 2026 ОНЫ ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АШИГЛАХ ХУГАЦАА

2026 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 70.0 мян.м3 элсэн чулуу олборлон борлуулахаар төлөвлөсөн.

Сүр сүлд" ХХК-ийн төсөл боловсруулах техникийн даалгавар, тус компанид МУ-ын ашигт малтмалын болон бусад хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн засаг даргын 2016 оны 05-р сарын 04-ний өдрийн А/340 тоот захирамжаар олгосон XV-11000047 (16/R042) тоот тусгай зөвшөөрөлтэй 96.9 га талбайн 14.2 га талбайд “Сүр сүлд” ХХК-ийн 2020 оны 5, 6-р саруудад хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, байр зүйн зураглалын материал, Улаанбаатар хотын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27–нд олгосон 87.35 га бүхий түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын 21/М037 тоот тусгай зөвшөөрөл авсан.

ЭБМЗ-ийн ХХ-15-02 тоот дүгнэлтийн 10 дахь заалтад “Ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг бодитой (В) ба боломжтой (С) нөөцөд тулгуурлан, эрх бүхий хуулийн эдгээдээр хийлгэх” гэсэн заалтын дагуу нөөц тооцсон талбайн хэсэгт уул уурхайн төсөл боловсруулах норм, баримтлах дүрэм журам, захиалагч талаас тавьсан шаардлагуудад нийцүүлж ТЭЗҮ-ийг гүйцэтгэсэн. 2022 онд бичиг баримтын бүрдэл дутуу байснаас эхний жилийн төлөвлөлтийн дагуу ажиллаж чадаагүй ба 2023 онд урьд онд олборлосон 25.0 мян3, 2023 оны 7 сард тэсэлсэн 10.2 мян3, нийт 35.2 мян.3 уулын чулуу ангилан буталж, 10-р сарын сүүлээр 12.39 мян.м3 уулын цул тэсэлсэн. 2024 онд өмнө жилд тэслэгдсэн 12.39 мян.м3 чулууг бутлан ангилж, олборлосон. 2026 оны төлөвлөгөөг ТЭЗҮ-ийн дагуу 3 дахь жилийн төлөвлөлтийн дагуу нөхөж төлөвлөлөө.

2026 оны уулын ажлын төлөвлөгөөг уурхайн олборлолтын ажлыг, ашигт малтмал ашиглалтын 21/М037 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий нийт 87.35 га газраас элсэн чулууны нөөц тооцсон 14.2 га талбай дахь Зүүн уурхайн В, С блокод +1417 м түвшнээс 1405м-ийн түвшин хүртэл уулын ажлыг хийхээр төлөвлөв. Учир нь өмнөх онд тэслэгдсэн 20 мян.м3 орчин уулын чулуулаг үлдсэн байна.

Уурхайгаас олборлосон чулууг талдаа 0.5-1км тээвэрлэн, бутлан ангилах үйлдвэрт 3 ангилал болгон эцсийн бүтээгдэхүүн болох дайргыг газар дээрээс нь бөөний үнээр борлуулна. Уурхайн ажиллах горим жилд 172 хоног, хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэл 8 цаг ажиллах ба бутлан ангилах хэсэг нь 192 хоног, хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цагаар ажиллахаар тус төлөвлөгөөнд төлөвлөлөө.

Өнгөрсөн жилийн олборлолтын байдал

Өнгөрсөн 2025 онд Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнүүдийг 04-р сард батлуулсан. 10-р сарын сүүлчээр цаг агаар, санхүүгийн байдал, ажиллах хүчний нөөц, тоног төхөөрөмж, машин механизмын эвдрэл гэмтлээс хамаарч төлөвлөлтийн дагуу уулын чулуулаг бутлан ангилж чадаагүй. Нийт 22 мян.м3 орчим чулуулаг бутлан ангилж, борлуулалт хийж байна. 2025 оны 5-р сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд өнгөрсөн 11-р сарын эхэнд цаг агаарын байдлаас шалтгаалан бүрэн зогссон. 2022-2025 онд нийт 81 мян.м3 уулын чулуулаг тэслэн 61 мян.м3 уулын цул бутлан ангилсан бөгөөд үлдсэн 20.0 мян.м3 чулууг ирэх 2026 оны эхээр бутлан ангилж, төлөвлөлтийн дагуу тэсэлгээ хийхээр төлөвлөж байна.

Уурхайн хүчин чадал, ажиллах горим

Улаанбаатар хотын зуурмагийн үйлдвэрүүд дээр хийсэн зах зээлийн судалгаа, гэрээг үндэслэн жилд 70.0 мян.м^3 элсэн чулуу олборлон борлуулах боломжтой гэж төсөл захиалагч үзсэн тул уурхайн хүчин чадал 1 дэх жилдээ хамгийн их буюу 89.3 мян.м^3 байна.

Үйлдвэрлэлийн ажиллах горим, ашиглалтын хугацааг уурхайн жилийн хүчин чадлаас хамааруулан тооцоолов. Ил уурхай нь улирлын чанартай дулааны улиралд (3-р сарын 15-наас 11-р сарын 15 хүртэл) 8 сарын хугацаанд жилд 172 хоног, хоногт 1 ээлж, ээлжинд 8 цагаар ажиллана.

Ажилчдын баяр ёслолын үеийн болон амралтын үеийн амрах хугацааг МУ-ын хөдөлмөрийн хуулийн дагуу уурхайг эзэмшигч компанийн захирлын тушаалаар зохицуулна.

- ✓ Жилд ажиллах хуанлийн хоног – 243
- ✓ Засварт зогсох хоног – 16
- ✓ Амралт, баяр ёслолын хоног –46
- ✓ Цаг агаарын болзошгүй саатлын хоног – 9
- ✓ Жинхэнэ ажиллах хоног – 172
- ✓ Хоногт ажиллах ээлж – 1
- ✓ Ээлжийн үргэлжлэх хугацаа – 8 цаг
- ✓ Уурхайн ээлжийн тооцооны бүтээл –406.97 м^3/ээлж буюу 1086тн /ээлж

1.3 УУРХАЙН ДЭД БҮТЭЦ

Зам тээвэр

Зүүн түрүүний элсэн чулууны ордын байрлах бүс нутаг нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг болно. Уурхайн ашиглалтын гол зам болох хөрсний гадаад овоолго хүртэлх 0.5-1.5 км, барилгын чулууг хүлээн авч нөөцлөх талбай хүртэлх 1.0 км автозамыг сайжруулсан шороон замаар хийх ба гадаад тээврийн зам нь хатуу хучилттай авто зам хүртэл 2-3 км ердийн шороон замууд байна. Цаашид Улаанбаатар хотод орших хэрэглэгчдэд хүрэх зам нь хатуу хучилттай зам байна. Эдгээр ердийн шороон авто замуудыг эвдрэл гэмтлээс хамгаалж, утгуурт ачигчаар тогтмол хусаж засварлаж байна. Уурхайн доторх технологийн болон гадаргуугийн автозамыг ашиглалтын хэвийн нөхцөлд байлгах, цаашид уулын ажлын өрнөлтэй уялдуулан уртасгах, шинээр тавих, замыг засаж арчлах зэрэг ажлуудыг замын норм дүрмийн дагуу гүйцэтгэнэ.

Ус шүүрүүлэлт ба усан хангамж

Зүүн түрүүний орд нь харьцангуй өндөршилтөөр 60м байгаа, мөн +1345 м-ийн түвшин хүртэл өрөмдлөгийн ажил хийхэд ус илрээгүй болно. Иймд ус шүүрүүлэлтийн ажил хийх шаардлагагүй гэж үзлээ. Уурхайн ахуйн болон технологийн усны хэрэгцээг гүний худгаар хангана.

Технологийн усан хангамж

“Зүүн түрүүн”-ий элсэн чулууны ил уурхайд технологийн зориулалтаар ус ашиглахгүй ба зөвхөн авто замыг шороо тоос босгохгүй байхын тулд байнга усална. Үүний тооцоог 2.16.2 хэсэгт хийсэн болно. Тоос дарах үйл ажиллагаанд 1800 тн ус зарцуулж, 1.7 сая төгрөг зарцуулна.

Ахуйн хэрэглээний усны тооцоо

Уурхайн талбайд баригдах ажиллагсдын сууринд амьдрах ажиллагсад усны үндсэн хэрэглэгч байна. Уурхайд нийт 27 хүн байнга ажиллана.

- ✓ Уурхайн сууринд:
- ✓ Халуун ус, угаалгын газар – 1ширхэг
- ✓ Ажилчдын гуанз – 1ширхэг
- ✓ Ариун цэврийн өрөө 1 ширхэг тус тус баригдана.
- ✓ СНиП-ээр 1 хүний усны хэрэглээ орон сууц, байранд 40-240л/хоног байх бөгөөд дунджаар 50 л/хоног гэж үзэн доорх аргачлалаар тооцов.
- ✓ Qхоног = Qхон х Nхүн : 1000 = 50*27 : 1000 = 1.35 м3/хоног
- ✓ Qхон – хоногийн дундаж ус зарцуулалт, 50 л/хүн

Уурхайн ахуйн хэрэглээний усны жилийн нийт хэрэглээ 172хоног*1.35м^3/хоног= =232м^3/жил байхад хэрэгцээг бүрэн хангах юм. Ахуйн хэрэглээний 1 тн усны үнэ (усны суурь үнэлгээ 9440 төг, үүний 10% нь) 944 төг гэвэл 232м^3/жил*944 төг=219.2 мян төг болж байна. (МУ-ын ЗГ-ын 2013 оны 326 тоот тогтоолын дагуу тооцов) Ахуйн хэрэглээний усыг өөрийн гүний худгаас шугамаар татаж хангана.

Барилга байгууламж.

Зүүн түрүүний элсэн чулууны ордын бодитой (В) нөөцийг олборлон жил бүр 100.0мян.м^3 түүхий эд борлуулна гэвэл “Сүр сүлд” ХХК 40 жил ажиллах ба ба цаашид олборлох чулууны нөөц арвин тул уурхайн туслах объектуудыг анхнаас нь чанартай материалаар барьж байгуулан ажиллагсдын хөдөлмөрлөх нөхцөлийг дээд зэргээр хангахын тулд тодорхой хэмжээний хөрөнгө, зохион байгуулалтын арга хэмжээ авах ёстой.

Уг ордын нөөц тогтоогдсон талбайн ойр орчимд барилга байшин байхгүй, хүн ам нягт оршин суудаггүй болно. Ил уурхайн бүрэлдэхүүнд:

- ✓ Нөөц тогтоогдсон 8.5 га талбай бүхий ил уурхай
- ✓ Бутлан ангилах хэсэг 0.4 га
- ✓ Шимт болон хоосон чулуулгийн овоолго 2.0 га
- ✓ Захиргааны байр контор - 1ш
- ✓ Ажиллагсдын амрах байр-80м2 талбай бүхий блокон барилга
- ✓ Хоолны газар -1ш
- ✓ Халуун ус, угаалгын газар, ариун цэврийн байгууламж 1ком
- ✓ Спортын талбай
- ✓ Автогараж, засварын газар, сэлбэг материалын агуулах -200 м2 талбай бүхий
- ✓ блокон барилга 1ш
- ✓ Уурхайн өндөр хүчдэлийн шугам, трансформатор- 1ком
- ✓ Харуулын байр 1ш
- ✓ Хамгаалалтын хашаа 2ш зэрэг орно.

Эдгээрийг аль болох бага талбай эзлүүлэн зөв зохион байгуулалттай байрлуулна.

Дээрх барилга байгууламж, объектуудыг уурхай нээгдэх үед ашиглалтанд өгсөн байх шаардлагатай ба барилгын ажлын норм, дүрэм стандартыг хангасан зураг төслийн дагуу мэргэжлийн байгууллагаар бариулна. Барилга байгууламжууд нь орчин үеийн дулаан тусгаарлах сайн чанарын материалаар хийгдэнэ.

Тосгоноос тодорхой зайд бохирын цэвэрлэх байгууламж, хуурай хог хаягдлын цэг байгуулан ариутгах, соруулах, зөөвөрлөх зэрэг арга хэмжээ тодорхой үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

Агуулахын аж ахуй

Ажиллагсдын хүнс, шатах тослох болон техник тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн шаардлагатай захиалгыг “Сүр сүлд” ХХК-ийн удирдлага хүлээн авч, ханган нийлүүлэх ажлыг хариуцна.

А.Хүнсний агуулах

Хүнсний агуулах нь хүнсний түүхий эдийг муутгахгүй зориулалтын хөргөгч бүхий байгууламж байна. Энэхүү байгууламж нь дулааны улиралд хурдан муудах мах, жимс, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүнийг 3-7 хоног, бусад хүнсний бүтээгдэхүүнийг 0.5 сар хадгалах боломжтой байхаар тоноглогдсон байна.

Б. Сэлбэг хэрэгслийн агуулах

Сэлбэг хэрэгслийн агуулах нь уурхайн тоног төхөөрөмжийн түргэн элэгдэх эд анги, ажилчдын тосгоны сантехник, цахилгаан тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, бусад туслах материалуудыг хадгалах түгээх зориулалттай байгууламж юм. Гарч болзошгүй гэмтэл саатлыг цаг алдалгүй хурдан хугацаанд арилгахад чиглэгдсэн сэлбэг хэрэгслийг энэ агуулахад нөөцөлнө. Зарим том оврын сэлбэг, эд ангийг гараашинд тусгай талбайд хадгална.

Засварын газар, техникийн гарааш.

Уурхайн өдөр тутмын ажлын гүйцэтгэж байгаа техник тоног төхөөрөмж, механизмыг засварлах, хүйтний улиралд зогсох зориулалттай битүү гарааш байх шаардлагатай. Энэ нь уурхайн үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд байрших боломжтой байна. Мөн механизмуудын дооройс засвар хийхэд зориулсан ям (нүх), 1-3 тн-ыг өргөгч тельфер, засварын багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон 20м х 10м х 4м хэмжээтэй битүү дээвэртэй засварын газар байна. Эдгээрийг барих материал нь галд тэсвэртэй, бат бөх байна. Засварын газрыг байгуулснаар төлөвлөгөөт болон урсгал засварыг зохион байгуулж, сул зогсолт гаргахгүй байх нөхцөлийг хангана. Уурхайн засварын хэсэг нь дотоод шаталтын хөдөлгүүртэй тоног төхөөрөмжийн урсгал ба үндсэн засвар, дугуй засвар зэрэг техник үйлчилгээний ажлуудыг хийнэ.

Мөн цахилгаан хөдөлгүүр, генератор, цахилгаан аппарат, хэмжих багаж хэрэгсэл, тоноглолын техникийн үйлчилгээ, урсгал засварыг гүйцэтгэнэ.

Засварын газарт гагнуурын аппарат, огтлогч, таслагч, өрөм, токарийн машин, дугуй засвар зэргийн хэрэгцээ шаардлагыг хангасан орчин үеийн тоног төхөөрөмжүүд байна. Уурхай орчимд гарсан жижиг гэмтлийг газар дээр нь очиж засварлана.

Цахилгаан хангамж, түүний эх үүсвэр

Сонгино хайрхан дүүргийн нутаг дахь 35/10 кВ-ийн дэд өртөөний 10кВ-ийн шонгоос салаалж 2.2 км-т орших Зүүн түрүүний элсэн чулууны уурхай хүртэл агаарын шугам татах ажлыг мэргэжлийн байгууллагын боловсруулсан зураг төслийн дагуу 10/0.4 кВ-ын КТПН 630 кВА-ийн трансформатор бүхий хүчдэл бууруулах дэд станцыг Эрчим хүчний барилга угсралт, худалдаа, засвар үйлчилгээний “Нарт импекс” ХХК 2021 оны 11-р сард суурилуулсан байна.

Дулаан хангамж

Уурхайн контор, орон сууц, цайны газар, авто граж, засварын газар зэрэг үндсэн объектууд нь дулааны улиралд ажиллах тул тухайлсан дулаан хангамжийн асуудал шаардагдахгүй юм. Харин хүйтний улиралд ажиллах сахиулын байрыг халаах шаардлагатай байна. Үүнийг орчин үеийн цахилгаан халаагуураар шийднэ. Хэрэглээг цахилгаан хангамжийн тооцоонд оруулан тооцов.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

№	Байгаль орчны бүрдэл	Товч тайлбар
1	Физик газарзүйн нөхцөл	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт харьяалагдана. Энд дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулстай ба эдгээр нь идэгдэл хэрчигдэлд нэлээд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь далайн түвшнээс дээш 1350-1400 м өргөгдсөн. Газар хөдлөлийн эрчимтэй бүсэд буюу 7-8 баллд оршдог.
2	Цаг уур уур амьсгал	Цаг уурын нөхцөлийг тодорхойлогч үндсэн элементүүдэд дүгнэлт хийхийн тулд Улаанбаатар хотын цаг уурын станцуудын 10-30 жилийн ажиглалтын материалыг харьцуулан үзэхэд агаарын жилийн дундаж температур Буянт-Ухаа орчимд -3.1°С, Хүрэл тогоот орчимд +1.6°С байна. Агаарын температурын хамгийн их ба бага утга нь зуны 7-р сар, өвлийн 1-р сард харгалзана. 7-р сарын агаарын дундаж температур нь Буянт-Ухаад +26.5°С, Хүрэл тогоотод +19°С болно. Үнэмлэхүй их, бага температур ч станц тус бүрд өөрийн онцлогтой байна. Тухайлбал: үнэмлэхүй бага температур голын хөндийд 1320 метр өндөр байрласан Хүрэл тогоотод 36.7°С хүрч байна. Үнэмлэхүй их температур Буянт-Ухаад +39°С, Хүрэл тогоотод +30.8°С болно. Улаанбаатар хот орчим нь Монголын бусад нутгийн нэгэн адил чийг дутагдлын нөхцөлд орших бөгөөд хур тунадас жилийн улирлуудад жигд бус хуваарилагдсан байдаг. Хур тунадасны зонхилох хэсэг (80-95 хувь) нь зун, намрын улиралд бууна. Үүний зэрэгцээ зуны сүүлчээр хэд хэдэн өдөр үргэлжлэн ордог зүсэр боroo байдаг. Хүйтний улиралд хур тунадас 11-34 мм байдаг нь цасан бүрхэвчийн зузаан бага байх үндсэн хүчин зүйл бөгөөд нарны цацраг харьцангуй их, агаарын чийг дутагдалтай байна.
3	Агаарын чанар	2022 онд агаарын шинжилгээ хийсэн ба гарсан дүнгээс харахад агаарт дахь SO2, NO2– ийн хэмжээ нь MNS 4585:2016 стандарт хэмжээг давсан үзүүлэлт байхгүй хэвийн хэмжээнд байсан. Мөн ашиглалтын талбайд нийт 2 цэгт нийт тоосжилтыг хэмжсэн. Тухайн хэмжилтийн дүнг MNS 4585:2016 стандарт үзүүлэлтэй харьцуулахад агаарт агуулагдах нийт тоос хэвийн/маш бага/ хэмжээнд гэсэн үр дүн гарсан байна.
4	Гадаргын болон газрын доорх ус	Улаанбаатар орчмын усан сүлжээг бүрдүүлэгч Туул гол түүний цутгал голуудын ай савд багтана. Тусгай зөвшөөрлийн талбай болон түүний орчимд байнгын урсгалтай гол байдаггүй. Тус талбайгаас хойд зүгт 1.9 км-т Зүүн түрүүний булаг бий. Тус булгийн ус хэдхэн метр урсаад шургадаг. Мөн хайгуулын талбайн зүүн талаар өнгөрч буй Зүүн түрүүний сайраар бороо ихтэй үед түр зуурын ус урсаж өнгөрдөг.
5	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Дүүргийн хэмжээнд тал хээрийн хүрэн, цайвар хүрэн хөрстэй. Судалгааны талбай нь Хэнтий салбар уулсад хамаарах ба нам бэсрэг уулын хээрийн ургамал зонхилно.

		Ургамлан нөмрөг нь хөл газрын ургамал их хэмжээгээр ургасан байна.
5	Амьтны аймаг	Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт оршиж байгаа тул хамгийн ан амьтан дайжиж ховордсон бүс нутагт хамаарч байна. Ан амьтадаас үнэг, зурам, оготно, жигүүртнээс шаазгай, шар шувуу, хэрээ, тагтаа зэрэг ан амьтадтай.
6	Нийгэм эдийн засаг	Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүрэг нь 1992 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу тухайн үеийн Октябрийн районоос өрх тусгаарласан. Сонгинохайрхан дүүрэг нь 32 хороотой, 124362.1 га нутаг дэвсгэртэй буюу Улаанбаатар хотын нийт газар нутгийн 25.5%-ийг эзэлнэ. 2019 оны байдлаар 1 км^2 нутагт 3766 хүн ноогдож байна. Суурин хүн амын тоо 333200 (Сонгино хайрхан дүүргийн Статистикийн эмхэтгэл 2019 он) байна. Сүүлийн жилүүдийн геологийн судалгаагаар үйлдвэрлэлийн ач холбогдолтой барилгын материалын түүхий эдийн олон ордууд нээгдэж, түүнийг түшиглэн барилгын материалын үйлдвэр, карьерын аж ахуйнууд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.
9	Дэд бүтэц.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын Зүүн түрүүний ам нэртэй 21/M037 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 33-р хорооны нутаг дэвсгэрт хамаарна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын талбай нь Улаанбаатар хотын төвөөс баруун хойд зүгт 21 км-т оршино. Автозам. Хотын төвөөс Дархан-Улаанбаатарыг холбосон (АН3) засмал замаар 18.0 км яваад баруун тийш эргэж төмөр замын доогуурх гарцаар гараад шороон замаар 3.0 км явж талбайд хүрнэ. Мөн Сонгино хайрхан дүүргийн -р хороо буюу Тахилтын амаар дамжиж талбайд хүрч болно.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“Сүр сүлд” ХХК-ийн “Зүүн түрүүн” нэртэй элсэн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

2.1 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 2. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	x			x			x		x	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x		x	
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
Зэрлэг амьтдын орон зай		x		x			x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										x
Бэлчээрийн байдал	x	x			x		x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x	x		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ				x		x				
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x			x			x		x	
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	

4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x			x			x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			x
Ажлын байр нэмэгдэх	x				x		x	x		
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x	x			x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x			x			x
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x			x	x	x			x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x		x				x
Хүчтэй салхи, уруйн үер	x			x			x			x
Дүн	18	3	0	10	11	4	17	2	13	6

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, дунд зэргийн нөлөөлөл нэлээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь

очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо ***магадлан жагсаах*** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 3. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	х			
2. Төслийн шийдэл, төлөвлөөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				х
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			х	
Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				х
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		х		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				х
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			х	
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			х	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			х	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			х	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		х		
5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				х

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтад хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

2.2 Төслийн гол сөрөг нөлөөллийг үнэлэх

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс төсөл хэрэгжих үеийн болон ашиглалтын үе шатанд хөрс, агаар, бэлчээр, газрын доорх ус зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд эдгээр нь голлох нөлөөлөлд багтана. Сөрөг нөлөөллийг байгаль орчны үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзлээ.

Газрын гадарга

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт харьяалагдана. Энд дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулстай ба эдгээр нь идэгдэл хэрчигдэлд нэлээд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй.

“Зүүн түрүүн”-ий уурхай, тэдгээрийн тоног төхөөрөмж, техникийн үйл ажиллагаанаас геоморфологийн нөхцөлд ихээхэн сөрөг нөлөөлөл үүсэх юм.

Цаг уур

Төсөл хэрэгжих орчны бүс нутаг нь эх газрын эрс тэс хахир ширүүн уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтийн шинж нь тэгш хэмийн 4 улирлын хуваарилалттай. Чийглэгдүү сэрүүн, нэн хүйтэн уур амьсгалын ангилалд хамрагдана.

Элсний ордыг ашиглах үеийн үйл ажиллагаанаас орон нутгийн уур амьсгалыг өөрчлөх сөрөг нөлөөлөл үүсэхээргүй байна.

Харин энэ төсөл нь Монгол орны уур амьсгалын эрс тэс нөлөөллийн дор хэрэгжих тул олборлолтын үед цаг агаар, уур амьсгалын нөхцөл ихээхэн нөлөөтэй байх болно.

Уурхайн үйл ажиллагаанаас орон нутгийн уур амьсгалыг өөрчлөх сөрөг нөлөөлөл байхгүй байна. Төсөл хэрэгжих явцад тоосжилт үүсэх зэргээр бохирдуулагч бодисын тоо хэмжээ нэмэгдэх ч стандарт хэмжээнээс давж, бохирдуулах хэмжээнд хүрч үйлчлэхгүй тул орон нутгийн уур амьсгалыг өөрчлөгч хүчин зүйл болж чадахгүй.

Агаарын чанар

Уурхай орчмын нутаг дэвсгэрийн хөрс эвдэгдэн тоосрох, хүнд даацын автомашины хөдөлгөөн, автомашин механизмын яндангаас гарах хорт хийн хаягдал нь агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг ихэсгэнэ. Нөлөөллийн эрчмийн хувьд технологийн үе шатуудад дунд зэрэг сөрөг нөлөөлөлтэй байна.

Уурхайг ашиглах үеийн ажлуудаас үүсэх тоосжилт, уг ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслээс гарах утаа зэрэг эх үүсвэрүүдээс тоосжилт, агаарын бохирдол үүснэ.

Усан орчин

Энэ талбайд байнгын урсгалтай гол, горхи байхгүй, зөвхөн ул чулуулгийн ан цавын болон хөндий хотгор дахь сэвсгэр хурдасны ус тохиолдоно. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэх явцад технологийн ус ашиглахгүй бөгөөд зөвхөн унд ахуйн болон тоосжилтыг багасгах зорилгоор ус ашиглах юм. Энэхүү усны хэрэгцээг төслийн талбай орчимд байх гүний худгаас зөөврөөр хэрэглэхээр төлөвлөсөн. Төслийн хүрээн дэх ахуйн хэрэгцээнд ашиглах усыг зөөврөөр авч ашиглах тул усны нөөцөд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.

Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих талбай нь Хөрс-газарзүйн мужлалтаар Төв Азийн бүсийн Хангайн их мужийн өргөргийн бүсшилийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойргийн нутагт хамрагдана. Тухайн нутагт хөрс үүсгэгч эх чулуулаг нь гол төлөв механик бүрэлдэхүүний болон сайр чулууны агууламж, карбонатын хэмжээгээр жигд биш делюви, пролювийн болон элювийн гаралтай сэвсгэр хурдсаас голлон тогтсон байна. Дээрх өргөргийн бүсшилийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойрогт уулын хар шороон, хар хүрэн, цайвар хүрэн, нугат хүрэн хөрс голлон тархана. Уурхай орчимд уулын хар хүрэн хөрс тархсан байна.

Уурхай орчмын хөрс нь авто машины болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртөнө. Хуурай хог хаягдлаар орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх зэргээр нөлөөлнө. Тээвэрлэлтээс хөрсний бүтэц эвдрэх, газрын гадарга, хөрс ахуйн хаягдал шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй.

Ургамлан нөмрөг

Ургамлын хэв шинжийн хувьд хээрийн ургамалшилт голлоно. Ургамлын тархалт өндрийн бүсжилтийн зүй тогтолд захирагдана. Алаг өвс-үетэн-хараганат хээр зонхилж биелэг өвс-алаг өвст уулын хээр нилээд тохиолдоно.

Уурхайн олборлолтын үед болон тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим буурах, ургамлын ургах чадвар муудах, ургамлан нөмрөг багасч халцгай газрын талбай нэмэгдсэнээр хөрс салхиар хийсэх, усанд урсах зэргээр газрын эвдрэл нэмэгдэх, хөл газрын ургамлууд бүлгэмдэлд түрснээр бэлчээрийн эдэлбэр газрын хэмжээ улам багасч тухайн нутагт бэлчээрийн даац хэтрэх зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй байна.

Амьтны аймагт нөлөөлөх байдал

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн баруун хэсэг болох Сонгинохайрхан дүүргийн 33-р хорооны хүн ам суурьшсан хэсгийн ойролцоо байрлах тул амьтны аймгийн төрөл зүйл харьцангуй цөөрч шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж цөөн тооны хөхтөн, зарим зүйл хот сууринд амьдардаг шувуу болон нүүдлийн шувууд байгаа болно. Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн ландшафт доройтсон унаган төрх нь алдагдаж техноген ландшафт үүссэнтэй холбоотой амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүн үндсэндээ дайжсан гэж хэлж болох юм.

Нийгэмд нөлөөлөх байдал

Төслийг хэрэгжүүлэхэд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг, харин уурхайн үйл ажиллагааны үед үүсэх машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, малын бэлчээр хумигдах зэргээр нөлөөлж болзошгүй.

Түүх соёлын дурсгалт зүйлс

Төсөл хэрэгжих орчны газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс одоогоор илрээгүй байгаа бөгөөд хэрвээ илэрвэл тэр даруйд холбогдох байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Үүнд:

- ✓ Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн
  нийцлийг хангах,
- ✓ БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- ✓ Орон нутагтай байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажилд хамтран ажиллах,
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах,

3.1Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар								
1.1	Төсөлд ашиглагдах машин механизм, дизель станцаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Уурхайн бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоонд оруулж. Агаар бохирдуулсны төлбөрийг төлж ажиллах	Уурхайд Ашиглагдаж байгаа бүх машин техник	-		Авто тээврийн хэрэгсэл	100.0	2026 он	MNS 5014:2003
1.2	Ашиглалтаас үүдэн агаар дах тоосны хэмжээ нэмэгдэх	Уурхайн дотоод замын усалгааг тогтмолд хийж байх. Хуурайшилт ихтэй өдрүүдэд усалгааны тоог нэмэх	Уурхайн дотоод зам				200.0	2026 он	MNS 4585:2007
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц								
2.1	Уурхайн ус ашиглалтаас үүдэн гарах нөлөөлөл	Ус ашиглах гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	300.0	2026 оны 1-р улиралд	Усны тухай хууль 31.2 зүйл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
2.2		Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах.	Төслийн хүрээнд		-	-			
2.3		Гүний худгийг тоолуурын ажиллагаанд хяналт тавьж ажиллах	Уурхайн худаг, цооног						
2.4		Усны төлбөрийг тухай бүрд нь төлж байх	Төслийн хүрээнд					2026 он	
3	Хөрсөн бүрхэвч								
3.1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад	Ашиглалтын талбайд шинээр эвдрэлд өртөх талбайн шимт хөрсийг 20-30 см зузаантайгаар хуулах	Төлөвлөлтийн дагуу шинээр эдэлбэр газарт олборлолт			Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	MNS 5916:2008 MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн

	байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө		хийсэн тохиолд					нийт хэмжээг тодорхойлох арга
3.2		Хуулсан шимт хөрснийг салхи болон усаар зөөгдөхөөргүй нөмөр газар байршуулах. Овоолгыг стандартын дагуу хэлбэршүүлэх				100.0	2026 он	
3.3		Ашиглалтын талбайд олон салаа зам гарахаас сэргийлж уурхайн дотоод замыг тэмдэгжүүлэх. Нэгдсэн маршрутаар явуулж хэвшүүлэх	Өмнөх жилүүдэд тавсан тэмдэг тэмдэглээг засаж сайжруулах			200.0	2026 он	
3.4	Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол авааранас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Машин механизмын эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг бетон хучилттай талбайд хийх	Засварын талбайд	-	-	100.0	2026 он	
		Нийт				**1000.0**		

3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Эхний жилд ил уурхайн зам, ангилах хэсгийн талбай, уурхайн өгөршсөн чулуун овоолго үүснэ. Ийм ашиглалтын талбайд нөхөн сэргээлт хийх талбай үүсэхгүй. Бид уурхайн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мөн Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор ашиглалтын талбай 100 ширхэг мод тарихаар төлөвлөлөө.

Хүснэгт 5. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8

1	Уурхайн талбайд ногоон байгууламж байгуулах	Ашиглалтын талбайд шинээр 50 ширхэг мод бут тариалах	ширхэг	-	-	1000.0	2026 он	
	Нийт					**1000.0**		

3.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Бид төлөвлөгөөт онд Нийслэлийн байгаль орчны газар болон Сонгинохайрхан дүүргийнх байгаль орчны газартай хамтран ажиллаж ажиллахаар төлөвлөсөн.

Хүснэгт 6. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Нийслэлийн байгаль орчны газартай хамтран ажиллах	Заасан ажлыг хийж гүйцэтгэх		-		1500.0		Байгаль орчны үнэлгээний тухай хууль
	Нийт					**1500.0**		

3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2026 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

3.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Бид 2022 онд ашиглалтын талбайд археологийн судалгааны ажил хийлгэсэн. Тухайн судалгааны дүнгээр ашиглалтын талбайд 3 ширхэг хиргисүүр олдсон. Төлөвлөгөөт онд бид тухайн газрууд нь ашиглалтын блокт өртөхгүй тул хашааж хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Цаашид уурхайн олборлолтын үед шинээр дурсгалт зүйл олдвол үйл ажиллагааг зогсоож соёлын өвийг хамгаалах газар мэдэгдэнэ.

3.6Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төсөлд химийн бодис ашиглагдахгүй боловч далд уурхайн өрөмдлөг тэсэлгээний ажилд хэрэглэгдэх тэсрэх бодист агуулагдаж буй химийн бодисын эрсдэлийн менежментийг дараах байдлаар төлөвлөсөн болно. Тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөлтэйгөөр компани тэсэлгээний мэргэжилтэн хийж гүйцэтгэдэг бөгөөд манай улсад өргөнөөр хэрэглэгдэж байгаа 32 мм диаметртэй, 300 мм урттай бортгон эмульсийн тэсрэх бодис, нонель систем (3-5м-тэй, цахилгаан бялт тэслүүр (ЭД), цочир дамжуулах шижим (ДШН-6), цахилгаан дамжуулах утас зэргийг хэрэглэдэг. Дээрх тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслүүдийг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай гэрээлэн худалдан авч, тээвэрлүүлж ажилладаг болно.

Тухайн 2026 онд хэрэглэгдэх ТБ болон тэсэлгээний хэрэгслийн хэмжээг дараах байдлаар төлөвлөсөн болно. Тэсэлгээний ажлыг Майнсфот ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ. Үүнд:

- ✓ Анфо – 50,4 тн
- ✓ Өдөөгч – 1760 тн
- ✓ ДША – 5110 м
- ✓ Цочир дам.шижим – 11440
- ✓ Ган дам.шижим – 704
- ✓ Дезонатор -1760 ш
- ✓ Удаашруулах реле – 110 ш
- ✓ Холбогч – 1870 ш

Хүснэгт 7. Осол эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1. Хөдөлмөр хамгаалал								
1.1	Ил уурхайн гэнэтийн аваар осол хөдөлмөр хамгааллын зөрчил илрэх	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Нийт ажилчид	-	-	ХАБ зардал	2026 он	
1.2		Ажил эхлэхээс өмнө хөдөлмөр хамгааллын заавар зөвлөгөөг өдөр бүр өгч байх	Нийт ажилчид			ХАБ зардал	2026 он	
2. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх								

2.1	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах Аянга цахилгаан, хэт халалт, хээрийн түймэр , гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах.	Уурхайн тосгон	-	-	100.0	2026 он	MNS5078-2001, MNS 5390:2004,
3. Байгалийн аюул гамшиг								
3.1	Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Байгалийн аюул гамшиг, аваар осол, гал түймрийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажилчдад	1 удаа	-	100.0	2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль,
4. Тэсрэх материалын агуулах								
4.1	Тэсэлгээний ажил болон тэсрэх материалын агуулахтай холбоотой сөрөг нөлөөлөл	Тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Тэсэлгээний ажил хийх бүрд	-	-	Гэрээгээр гүйцэтгүүлэх	2026 он	
		Нийт				**200.0**		

3.7Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8.Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1		Ахуйн гаралтай хог хаягдлыг СХД-ийн ТҮК-тай	-	-		-		2026 онд	Хог хаягдлын тухай хууль

	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах	гэрээ байгуулж сард нэг удаа тээвэрлүүлж байх.							
2		Уурхайн бие засах газар болон хог хаягдлын цэгүүдэд ариутгал халдваргүйжилд хийх	Уурхайн бие засах шазар хаягдлын цэг	2-3 цэгт	-	-	500.0	2026 он	
4		Уурхайн ашиглалтаас гарсан аюултай хог хаягдлыг ашиглалтын талбайд түр хадгалах	Аюултай хог хаягдлыг хадгалах цэгт	-	-	-	100.0	2026 он	
5	Аюултай хог хаягдал	Ашиглалтаас гарсан аюултай хог хаягдлыг дахин боловсруулах цэгт нийлүүлэх.					400.0	2026 он	
		Нийт					**1000.0**		

3.8Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой хамтран ажиллах.

Хүснэгт 9. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1.Агаарын чанар								
1.1	Хүхэрлэг хий (SO2) Азотын давхар исэл (NO2) Нийт тоосонцор	- Ил уурхайн талбайд - Баяжуулах хэсэгт - Уурхайн тосгон	2026 оны 6-р сард 2026 оны 10 сард	1		400.0	Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой гэрээ байгуулах	MNS5061:2001 MNS3113:1981 MNS0017.2.5.12:8988
2.Хөрсөн бүрхэвч								
2.1	Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO3), хөдөлгөөнт кали (K2O), хөдөлгөөнт фосфор	- Эрүүл талбай - Карьер	2026 оны 6-р сард 2026 оны 10 сард	2		400.0	Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой	MNS 2305-94 MNS 3298-1991 MNS 5850:2008

	(P2O5), Шингээгдсэн сууриуд Ca, Mg Хөрсөнд агуулагдах хүнд металл						гэрээ байгуулах	
3.Усан орчин								
	Ca, Mg, Cl, SO4, NO2, NO3, NH4, HCO3, Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар,	- Уурхайн худаг	2026 оны 6-р 2026 оны 10 сард	2		200.0	Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой гэрээ байгуулах	MNS0900:1992 MNS3935:1986 MNS3936:1986 MNS4432:1997 MNS3934:1986 MNS5667-2:2001 MNS4867:1999
		Нийт				**800.0**		

3.9Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь 2026 он			Хариусан албан тушаалтан	Тайлбар
			Сар 1.2.3.	Сар 4.5.6.7	Сар 8.9.10.11		
	1	2	3	4	5	6	7
1	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулах				X	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
2	2026 оны БОМТөлөвлөгөө боловсруулах				X	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
	Нийт						

3.10. Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.

Хүснэгт 11. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Нийслэлийн БОГазар	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, тайлан хэлбэрээр хүргүүлэх ба шаардлагатай тохиолдолд зохиогдох хуралд илтгэл хэлбэрээр тайлагнана.	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2026 оны 11 дүгээр сард багтаан		Компаний захирал болон Байгаль орчны ажилтан	
2	БОУАӨЯ-ны ХБОБҮГ-Т	БОМТ-ий биелэлтийн тайланг А-618 тоот журмын дагуу боловсруулан хүргүүлж, хянуулан батлуулах	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2026 оны 12 дугаар сард багтаах	ҮАЗ	Компаний захирал болон Байгаль орчны ажилтан	
	Нийт						

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Мэдээллийн төрөл	Нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1000.0
2	Нөхөн сэргээлтийн зардал	1000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	1500.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	500.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	1000.0
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	
10	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	1000.0
	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв / Сая төгрөг/	**6000.0**